

Sika® Ceram Tile Grout

Полимерээр баяжуулсан плитаны чигжээс

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sika® Ceram Tile Grout нь өндөр чанарын полимерээр баяжуулсан, нэг биет цементэн суурьтай өнгөт плитаны чигжээс юм.

Sika® Ceram Tile Grout нь усан хялбархан уусч, плитаны хоорондох зайг чигжих, ус чийг болон агшилтанд тэсвэртэй бүтээгдэхүүн юм

Sika® Ceram Tile Grout нь цагаан, саарал өнгөтэй байдаг.

Хэрэглээ:

Sika® Ceram Tile Grout –н хэрэглээ:

- Барилгын гадна талын плитаны хоорондын зайг чигжих зорилгоор (6 мм хүртэлх өргөнтэй)
 - Барилгын дотор талын плитаны хоорондын зайг чигжих зорилгоор (6 мм хүртэлх өргөнтэй)
 - Sika® Ceram-100 бүтээгдэхүүнтэй хавсарч хэрэглэх тохиолдолд
-

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Хэрэглэхэд хялбар бэлэн зуурмаг – Зөвхөн ус нэмэх шаардлагатай
 - Ажиллах чадвар сайн, бүтээмж өндөр
 - Ус, чийгнээс хамгаалагдсан
 - Агшилт бага, хагаралтад тэсвэртэй
 - Байгал орчинд ээлтэй
 - Sika Ceram Tile Adhesive – плитаны цавуутай хавсарч хэрэглэхэд тохиромжтой
 - Олон өнгөний сонголттой
-



Бүтээгдэхүүний мэдээллийн хуудас

Хольцын найрлага	25 кг савлагаатай бүтээгдэхүүнийг ойролцоогоор 6,5 литр устай хольно.
Нягт	Шингэн зуурмагийн нягт:~ 1.9 кг/л
Чигжээсний өргөн	6 мм хүртэл
Бэхжилтийн хугацаа	~45 минут (+25°C орчинд)
Шулуун агшилт	< 0,1% эхний өдөр < 0,2% 7 хоногт өдөр
Сав баглаа боодол	25 кг цаасан ууттай
Өнгө	Саарал / цагаан
Хадгалалт	Сав баглаа боодол онгойж, цоороогүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 9 сарын хугацаанд хуурай сэрүүн нөхцөлд хадгална. Хөлдөх аюулгүй

Хэрэглэх заавар

Sika® Ceram Tile Grout бүтээгдэхүүнийг Sika Ceram Плитаны цавуутай хавсарч хэрэглэх тохиолдолд, плитаны цавууг түрхсэнээс хойш хамгийн багадаа 24 цаг бэхжүүлсэний дараагаар плитаны чигжээсийг хэрэглэх шаардлагатай.

Чигжих гадаргууг бат бэх байж, элдэв бохирдол, тоосноос сайтар цэвэрлэсэн байх шаардлагатай. Сул, хөдөлгөөнтэй, бутрамтгай хэсгүүдийг чигжээсний түрхлэг хэрэглэхээсээ өмнө хуулж авах шаардлагатай.

Зориулалтын цахилгаан холигчоор зуурах нь тохиромжтой. Нунтаг бүтээгдэхүүнээ цэвэр усан дээр бага багаар хийж нэгэн жигд хурдтайгаар холих ба ямар нэгэн бөмбөлөг үүсээгүй жигд ууссан зуурмаг болгох хэрэгтэй. 25 кг савлагаатай зуурмагийг ойролцоогоор 6,5 л усаар хольж зуурах бөгөөд хольсоны дараа бүтээгдэхүүнээ 5 минутын хугацаанд амрааж байгаад түрхэнэ.

Sika® Ceram Tile Grout бүтээгдэхүүнийг зориулалтын резинэн ниви ашиглаж түрхэх ба тойрог болон ташуу чиглэлээр плитаны хооронд сайтар чигжин дүүргэж хооронд нь барьцалдуулж өгнө. Чигжих явцдаа илүүдэл зуурмагаа авч, зуурмаг хатхаас өмнө плитагаа чийгтэй цэвэр даавуугаар арчиж байх шаардлагатай.

Плитаны хоорондох чигжээсийг цэвэр үзэмжтэй харагдуулахын тулд үзүүлтэй багаж болон резинэн бээлийтэй хуруугаараа чигжээс зуурмагийн дээгүүр хөнгөн дарж өгч болно.

Анхаарах: Плитаны чигжээсний өнгө нь орчны нөлөө, гүйцэтгэх аргачлал, плитаны шинж чанар болон усны хэмжээ зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан бодит байдал дээр өөр гарах боломжтой. Иймээс нарийн тодруулахын тулд урьдчилан туршиж үзэхийг зөвлөж байна.

Цэвэрлэгээ	<p>Плитаны гадаргууд наалдсан чигжээсний зуурмаг дөнгөж хатах зуур чийгтэй цэвэр даавуугаар плитаг өнгөлөх хэрэгтэй.</p> <p>Бүтээгдэхүүнийг хэрэглэж дууссаны дараа зуурмаг хатахаас өмнө багажуудаа усаар сайтар цэвэрлэ.</p>
Аюулгүй ажиллагаа	<p>Sika® Ceram Tile Grout нь шүлтлэг гаралтай бүтээгдэхүүн учраас мэдрэмтгийн арьстай хүнд цочрол өгч болзошгүй. Иймээс цементийн адил амны хаалт, бээлий, нүдний шил г.м хувийн хамгаалах хэрэгсэл зүүж хэрэглэхийг зөвлөж байна. Арьсанд хүрсэн тохиолдолд цэвэр усаар угаах хэрэгтэй. Нүд рүү орсон тохиолдолд урсгал усаар нүдээ сайтар зайлаад эмчид хандахыг зөвлөж байна. Sika® Ceram Tile Grout нь хоргүй, шатамхай бус бүтээгдэхүүн юм.</p>
Хууль эрх зүйн мэдээлэл	<p>Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.</p>

Sika Hongkong Ltd.
Rm. 1507-12, 15/F.,
Block A, New Trade Plaza,
6 On Ping Street, Shatin, N.T.
Hong Kong

Tel: +852 2686 8108
Fax: +852 2645 3671
email: marketing@sika.com.hk

